



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 579

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.3, 3.4 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны "Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны давсан орлогыг зарцуулах тухай" 275 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн албан хэрэгцээнд зориулан, байгууллагын үйл ажиллагааны давсан орлогын эх үүсвэрээр 32,000,000.00 (гучин хоёр сая) төгрөгт багтаан үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Энх-Амар, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал Б.Ганзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ГАВАА

0002585

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
..549..... дугаар тогтоолын хавсралт



Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн худалдан авах
автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Суудлын тоо 12 хүртэл, хөдөлгүүрийн багтаамж 3001 cc хүртэл,	ш	1	35,000,000.00
Нийт дүн			1	35,000,000.00
				(гучин таван сая)